

2019-10-22

НҮБ-ЫН НЭН БУУРАЙ ХӨГЖИЛТЭЙ, ДАЛАЙД ГАРЦГҮЙ ХӨГЖИЖ БУЙ БОЛОН
АРЛЫН ЖИЖИГ ОРНУУДЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ДЭЭД ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР
“ДАЛАЙД ГАРЦГҮЙ ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДАД ДАМЖИН ӨНГӨРӨХ ТЭЭВРИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ, БҮТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АСУУДЛААРХ”
ОЛОН УЛСЫН ХУРЛЫН ИЛТГЭЛ

Эрхэм хүндэт зочид төлөөлөгчид,
Хүндэт хадагтай, ноёд оо,

Юуны өмнө Монгол Улсын ЗТХЯ-ны нэрийн өмнөөс НҮБ-ын Нэн буурай хөгжилтэй, далайд гарцгүй хөгжиж буй болон арлын жижиг орнуудын асуудал эрхэлсэн дээд төлөөлөгчийн газрын дэмжлэгтэй зохион байгуулж чухал арга хэмжээнд оролцож байгаа зочид төлөөлөгчид энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд зам, тээврийн салбарыг “Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх” зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улс дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх хүрээнд хоёр болон гурван талт хэлэлцээр байгуулж, олон улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, конвенцид нэгдэж үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.

Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын асуудлаарх Венийн үйл ажиллагааны хөтөлбөрийн дунд хугацааны хөтөлбөрийн нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа “Дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх бодлого” болон “Дэд бүтцийн хөгжил ба ашиглалтын бэлэн байдал” зорилтын хүрээнд тээврийн салбарын бодлого, төлөвлөлт боловсруулан хэрэгжүүлж байна.

Узбекистан Улсын Ташкент хотноо 2016 оны 6 сард Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын уулзалтаар “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг баталсан. Энэхүү хөтөлбөрт гурван улсын нийгэм, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нийт 32 төслийн 13 төсөл нь дамжин өнгөрөх тээврийн коридорын дэд бүтцийг хөгжүүлэх зорилттой байна.

ОХУ-ын Москва хотноо 2016 оны 12 дугаар сард Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурсан. Энэхүү хэлэлцээр нь “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулсан анхны баримт бичиг болж байгаараа чухал ач холбогдолтой юм. “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах Хамтарсан хорооны анхдугаар хурал БНХАУ-ын Манжуур хотноо 2019 оны 7 дугаар сард зохиогдож хэлэлцээрийн

хүрээнд автотээвэрлэлт гүйцэтгэхтэй холбоотой шийдвэрүүд гарсаныг дуулгахад таатай байна.

Дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улс Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулсан билээ.

Монгол Улсын хилийн боомтоор дамжин өнгөрөх чингэлэгтэй ачаа тээврийн нэвтрэх чадавхыг сайжруулах, хөнгөвчлөх ажлын хүрээнд “УБТЗ” ХНН нь ОХУ-ын чиглэлийн галт тэрэгний мэдээллийг цахим хэлбэрээр солилцож эхэлсэн, дамжин өнгөрөх 40 футын чингэлгийн галт тэрэгний тээврийн тарифыг 61%, Замын-Үүд төмөр замын өртөөнд шилжүүлэн ачилтын зардлыг 33% тус тус хөнгөлж, улсын хил нэвтрэлтийн технологийн горимд өөрчлөлт оруулж ОХУ-аас БНХАУ-ын чиглэлд аялах хугацааг 27% буюу 28 цаг, эсрэг чиглэлд 26% буюу 31 цаг болгосны үр дүнд 2018 онд дамжин өнгөрөх тээвэр өмнөх онтой харьцуулахад 8,9% өссөн дүнтэй, харин 2019 оны эцсээр энэ тоо өссөх хандлагатай байгаа нь эдийн засгийн коридорын сайн туршлагын нэг жишээ гэж үзэж байна.

Ерөнхий сайдын 2018 оны 104 тоот захирамжаар Монгол Улсад олон улсын хуурай боомт байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судалж санал боловсруулах, гадаад улс, олон улсын байгууллагын дэмжлэг авч, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулсан. Энэхүү Ажлын хэсэг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулан ажиллаж байна.

“Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх” төслийн хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд суманд холимог тээврийн логистикийн төвийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр байгуулсан. Энэхүү логистикийн төвийг ашиглалтад оруулснаар дамжин өнгөрөх ачаа тээврийн хэмжээ, түүний үр ашгийг дээшлүүлэх, холимог тээврийн системийг хөгжүүлэхээс гадна царигийн зөрүүтэй төмөр замуудын шилжүүлэн ачилтын хугацааг багасгах зорилготой. Улмаар Замын-Үүд өртөөний ачаа боловсруулах хүчин чадал, импорт, экспорт, дамжин өнгөрөх тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх, цаашлаад Монгол Улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Далайд гарцгүй Монгол Улсын экспортын бүтээгдэхүүнийг далайн боомтоор дамжуулан гуравдагч улсын зах зээлд гаргах зорилтын хүрээнд “Төрөөс төмөр замын тээврийг хөгжүүлэх бодлого”-д тусгагдсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлд 414,6 км төмөр замын бүтээн байгуулалтыг доотодын нөөц бололцоог дайчлан хэрэгжүүлж байгааг онцлон тэмдэглэмээр байна.

Монгол, Хятадын хилийн боомт Замын-Үүд-Эрээний тээврийн ачааллыг бууруулах, дамжин өнгөрөх тээврийг нэмэгдүүлэх зорилгоор Сайншанд-Зүүнбаян чиглэлийг үргэлжлүүлэн Ханги-Мандал (БНХАУ) хилийн боомт хүртэл 280 орчим км төмөр зам барих төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Төмөр замын Төв коридорын хөгжил шинэчлэлийн ажлууд:

- “УБТЗ” ХНН-ийн Сүхбаатар-Улаанбаатар-Замын-Үүд өртөө хооронд төмөр замын дохиоллын системийг шинэчлэх ажил хийгдээд дуусч байна /2016-2019 он/;
- “УБТЗ” ХНН-ийн Зүүнхараа дахь ачааны вагон депогийн өргөтгөлийн ажил хийж ашиглалтад оруулсан. /2017-2019 он/;
- Төмөр замын дэд бүтцийн шинэчлэлийн ажил /Р65 зам төмөр, төмөр бетон дэртэй, 30-35 см зузаан балласт/ /2016-2019 он/

Авто замын Төв коридорын шинэчлэлийн ажлууд:

- Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замд өргөтгөл, шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлж байна. Хэрэгжүүлэх хугацаа 2019-2020 он;
- Монгол Улсын Засгийн газар Улаанбаатар-Дархан чиглэлийн 204,6 км авто замыг 4 эгнээтэй болгон өргөтгөж, шинэчлэх ажлыг хэрэгжүүлж байна. /2019 оноос эхэлсэн/

Орон орны төлөөлөгчид, олон улсын байгууллагууд болон хөрөнгө оруулагчид хамтран зам, тээврийн салбарт оруулах өөрсдийн хувь нэмэр, нөөц бололцоо, боломж, чадамжийн талаар өргөн хүрээнд үр дүнтэй хэлэлцэнэ гэдэгт итгэлтэй байна.

Ази, Европыг холбох гүүр болсон Монгол Улс нь бусад улс орнуудтай идэвхтэй хамтран ажиллаж, Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэхэд хүчин чармайлт гарган, хувь нэмрээ оруулна гэдэгт итгэл дүүрэн байгааг дуулгахад таатай байна.

Энэхүү өндөр ач холбогдолтой энэхүү хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.